

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 он

АГУУЛГА

- НЭГ.** НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- ХОЁР.** НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА
- ГУРАВ.** БИЧИГ ХЭРЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР
- ДӨРӨВ.** СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР
- ТАВ.** ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР
- ЗУРГАА.** АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР
- ДОЛОО.** ЭД ХӨРӨНГӨ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
- НАЙМ.** ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
- ЕС.** ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
- АРАВ.** САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
- АРВАН НЭГ.** МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.11.17

Баруун-Урт хот

НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд, холбогдох тогтоол шийдвэр, журмуудын хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аргачлал загвар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу төлөвлөгөөний төслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, 2000 тэмдэгтэд багтаан товч тодорхой, бодитой, үг үсгийн алдааг хянан тогтоосон хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж батлуулсан.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 зорилт, 28 арга хэмжээний хүрээнд батлагдан, хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс тасаг нэгжүүд, цаашлаад тасаг нэгжээс улсын бүртгэгч нартай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргатай байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.

ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтэс нь 2023 онд аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран нийт ажилтан албан хаагчийг эрт үзлэгт бүрэн хамрагдуулан ажиллаа.

Голомт банктай хамтран “Хуримтлалыг зуршил болгоё” аяны хүрээнд хуримтлалын ач тус, хэрхэн

ХААН банктай хамтран “Төр хувийн хэвшлийн түншлэл”-ээр тус банк нийгмийн хариуцлагын хүрээнд 5 ширхэг камер, 1 ширхэг иж бүрэн компьютерийг

шийдэж өгснөөр архивын байрны хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал сайжран архивыг бүрэн камержуулаад байна.

Хэлтсийн нийт 23 албан хаагчаас “Нууцын баталгааг” гаргуулан авсан “2023 онд ХУБ болон ЭХЭУБүртгэгчээр шинээр томилогдсон албан хаагчийн нууцын баталгааг шинэчлэн гаргуулан авч мэдээлэлийн аюулгүй байдлыг ханган ажиллаа.

ГУРАВ. БИЧИГ ХЭРЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Албан хэрэг хөтлөлтөд онцгой анхааран, “eDOC” системийн ашиглалтыг сайжруулан, ирсэн явсан бичгүүдийг хууль журамд заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд тус хэлтэст ирсэн бичиг-640, үүнээс хариутай-221, хариугүй-279, явсан-500 бичиг бүртгэгдсэн байх ба нийт-1140 албан бичиг EDOC программд оруулан хугацаандаа шийдвэрлэлээ.

Албан бичгийн хугацаа шийдвэрлэлт хуулийн хугацаандаа хийгдсэн ба хугацаа сунгуулсан, хугацаа хоцроосон, хэтэрсэн зөрчилтэй албан бичиг байхгүй.

Иргэд болон хуулийн этгээдээс 1 талархал ЭХЭБ- 3, ИУБ-11, ХЭУБ-2 Хүний нөөцтэй холбоотой 7 өргөдөл гомдол ирсэн байх бөгөөд эдгээр өргөдөл гомдлын хариуг ажлын 3-7 хоногийн дотор шийдвэрлэж иргэнд хариуг нь өгсөн. Тус хэлтэс нь албан хэрэг хөтлөлтийн “Edoc”, ERP системийг албан хэрэг хөтлөлтөнд хэрэглэж, тоон гарын үсгийг ашиглан албан бичгийг илгээж байна.

ДӨРӨВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Хэлтсийн хэмжээнд төрийн захиргааны 20 албан хаагч нийт 100 хичээл үзэх шаардлагатайгаас 96 хичээл үзэж судалсан байна. Хэлтсийн бие даан судлах хичээлийг үзсэн байдлын биелэлт 96%-тай байна. Төрийн захиргааны албан хаагчдаас 1 төрлийн хичээлийг судалсан хүн 0, 2 төрлийн хичээлийг үзэж судалсан хүн 0, 3 төрлийн хичээлийг үзэж судалсан хүн 1, 4 төрлийн хичээлийг үзэж судалсан хүн 2, 5 төрлийн хичээлийг үзэж судалсан хүн 17 байна.

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр АНУ-ын Дипломат аюулгүй байдлын албанаас УБЕГ-тай хамтран зохион байгуулсан цахим сургалтад 3 албан хаагч;

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Цахим гадаад паспортын бүртгэлийн программын танилцуулах” цахим сургалтад 10 албан хаагч;

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Цахим гадаад паспорт хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой программын дадлага олгох” танхим, онлайн сургалтад 2 албан хаагч;

2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагч” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч,

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Амьдрах урлаг ба йога бясалгал” сэдэвт цахим сургалтад хэлтсийн 2 албан хаагч;

2023 оны 04 дүгээр сарын 24-нийн өдөр Улсын бүртгэлийн газрын Иргэний улсын бүртгэлийн газар, хяналт шалгалтын газраас хамтран зохион байгуулсан “Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хөтлөх талаар” цахим сургалтад Улсын ахлах бүртгэгч Сайнбаяр,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг танилцуулах хэлэлцүүлэгт 3 албан хаагч цахимаар хамрагдсан. Тайлант хугацаанд 9 сургалтад хаагч нар хамрагдсан байна.

ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын мөрөөр хяналт шалгалт хийн, хяналтын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэхээр нийт 76 дүгнэлт гарган зөрчлийг шийдвэрлэсэн.

Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх хэсгийг үндэслэн иргэний үнэмлэхний 25, 45 насны хугацаа сунгалтын бүртгэлээ хуулийн хугацаанд бүртгүүлээгүй болон Зөрчлийн тухай хуулийн 15.24.4 дэх заалтыг үндэслэн иргэний үнэмлэх хаяж гээсэн, гэмтээсэн 141 иргэн, 2 хуулийн этгээдэд 4075000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

2023 оны 05 дугаар сарын 5-наас 05 дугаар сарын 05-ны хооронд Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж батлан, хяналт шалгалтын үйл ажиллагааг хийж байна.

Удирдамжийн дагуу Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр улсын бүртгэгч нарын бүртгэсэн 310 бүртгэлд дотоод хяналт шалгалт хийсэн.

ЗУРГАА. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын тогтоолын дагуу тус хэлтсийн ажлын байр нь хуучнаар Мэргэжлийн хяналтын газрын байрлуу нүүсэнтэй холбогдуулан улсын бүртгэлийн архивыг нүүлгэн шилжүүлэх, хувийн хэргийг архивт байршуулах ажлыг хэлтсийн дарга болон хяналтын улсын байцаагчийн удирдлага, хяналт дор дотоод нөөцөө дайчлан зохион байгуулж, хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна.

УБЕГ-аас архивын стандарт шаардлагад нийцсэн нягтаршуулсан шүүгээ 6-г нэмж авч угсран хувийн хэргүүдийг байршуулсан. Шүүгээнүүдэд дугаарлалт, заагуур, чиглэл заах сум зэргийг хийж тавиур бүрт байршуулсан. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хувийн хэргүүдийн хавтсыг шаардлага хангасан цаасан хавтсаар бүрэн сольж, эрхийн улсын бүртгэлийн дугааруудыг шинээр хийж хайрцаг бүрт бүрэн сольж хийсэн нь архив нь эмх цэгцтэй, стандартын шаардлагад нийцэж, хувийн хэрэг татах хугацааг хэмнэсэн ажил боллоо.




Зураг: Архивыг нүүлгэх явц



Зураг :Архивын нягтаршуулсан шүүгээ угсарсны дараа

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын 15617 хувийн хэрэгт болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын 1370 хувийн хэрэгт хийх тооллогыг бүрэн хийж, архивт стандартын дагуу байршуулж дууссан.

Мөн архивын хувийн хэргийн хавтсыг бүрэн шинэчлэн сольж, эрхийн улсын бүртгэлийн дугааруудыг шинээр хийж сольсон, Архивын шүүгээнүүдэд заагуур, чиглэлүүдийг хийж стандартын дагуу байршуулсан.



Зураг. Шүүгээнүүдэд дугаарлалт, заагуур, чиглэл хийсний дараа



Зураг. Хувийн хэргийн хавтсыг цаасан хавтсаар шинэчлэн солив

Шинээр томилогдсон архивч Б.Батзаяаг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт 2023 оны 01 дүгээр сарын 28-аас 01 дүгээр сарын 31-ний өдрүүдэд дадлагажуулсан. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн архивын тасгийн ахлах мэргэжилтнийг урьж, архивын стандарт шаардлага, мөрдөгдөх дүрэм журмуудын талаар зааварчилгаа авч ажиллаа. Архивын үйл ажиллагаатай холбоотой хууль, журмуудыг хэвлэн хавтаслаж, гарын авлага бэлтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 тушаалын хавсралтын Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.5.1-нд заасны дагуу аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн хувийн хэрэг улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 өдөр, анхны бүртгэлийг ажлын 5 хоногийн дотор гэсэн журмыг үндэслэн улсын бүртгэгч нараас мэдүүлэг, нотлох баримт, анхны бүртгэлийг архивт хүлээн авч ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн тасгийн 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримт, хэргийн 23 боть, тоон гарын үсэг олгосон баримтын 3 боть, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 2 боть нийт 27 боть эх материалыг архивт тушаав.


ДОЛОО. ЭД ХӨРӨНГӨ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол гарсантай холбогдуулан байгууллагын ажлын байрыг хуучнаар Мэргэжлийн хяналтын газрын байрлуу нүүлгэн шилжүүлсэн. Улмаар архивын цаасан эх нотлох баримтыг нүүлгэн шилжүүлэх, архивын танхим, үйлчилгээний танхим, өрөө тасалгаа гаргаж үйлчилгээний стандартад нийцүүлэн засварлаж тохижуулах, хаягжуулах зэрэг ажилд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хамт олон идэвхи санаачлагатайгаар оролцож, өөрсдийн дотоод нөөц бололцоо, хүч хөдөлмөрөөр үйлчилгээний танхимтай болсноор, иргэн хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй хүргэж, иргэдэд тав тухтай үйлчилгээ авах, албан хаагчдад ажиллах таатай орчинг бүрдүүлж өгсөн.





Зураг: Үйлчилгээний танхим, өрөө тасалгааны засвар хийх явц



Зураг: Засвар хийсний дараахь байдал

Тус онд хэлтсийн даргын А/14 тоот тушаалаар байгуулагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг тоолох комиссын бүрэлдэхүүнтэйгээр архивын 15617 хувийн хэрэгт тооллого хийж, цахим сантай тулган, хувийн хэргийг архивт стандартад нийцүүлэн байршуулах ажлыг зохион байгуулсан.



Зураг: Тооллого хийх, хувийн хэргийн хавтасны дугаарлалт солих явц

Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээний тоон мэдээг нэгтгэвэл:

- ✚ Иргэн, хуулийн этгээдээс нийт 4772 мэдүүлгийг хурууны хээгээр хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнээс сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан зэргэлдээ 6 сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэн, 441 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлээд байна.
- ✚ Анхны бүртгэл нийт - 550
- ✚ Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл - 908
- ✚ Барьцааны гэрээ болон бусад гэрээ – 3090
- ✚ Бүртгэлд өөрчлөлт оруулах – 146 бүртгэлийг тус тус хөтөлсөн байна.

Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр болон хууль хяналтын байгууллагад нийт 83 лавлагаа, мэдээллийг хууль, журмын дагуу олгоод байна.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралтаар “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам” батлагдаж Хүүхдийн мөнгө олгох өрхийг тодорхойлох босго шугамыг шинэчлэн тогтоосноор Эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотойгоор иргэдээс өргөдөл гомдол олноор ирсэн. Энэ асуудлыг тухайн цаг цаг алдалгүй шийдвэрлэх ажлыг зохион байгуулж Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу хяналтын улсын байцаагчтай хамтран эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл хөтөлсөн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээр улсын байцаагчийн 55 дүгнэлт гаргуулан зөрчлийг арилгах, цахим мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах, дархардсан бүртгэлийг хаах зэрэг ажлыг цаг тухайд нь шийдвэрлэн ажилласнаар хүүхдийн мөнгөн тэтгэмжээ авах нөхцөл бололцоог бүрдүүлж, иргэдэд ээлтэй, нээлттэй үйлчилж, бүртгэлийн байгууллагын нэр хүндийг өргөн ажиллалаа.

Мөн УБЕГ, ХШГ, ЭХЭУБГ болон холбогдох бусад байгууллагаас албан бичгээр ирүүлсэн 69 чиглэл зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар болон тушаал журмыг хяналтандаа авч улсын бүртгэгч нарт тухай бүрд танилцуулан, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд ЭХЭУБГ-аас ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд эд хөрөнгийн талбайн хэмжээ алдаатай 17, хөрөнгийн цахимжуулалтын болон хаагдсан бүртгэлийн өмчлөгчийн төлөв алдаатай 26, цахим мэдээллийн санд нэгж талбарын дугаарыг оруулаагүй 9, газрын зориулалтыг оруулаагүй, эсвэл зөрүүтэй оруулсан 278 бүртгэл нийт жагсаалтаар ирүүлсэн 330 бүртгэл болон цахимжуулалтын үед метаг зөрүүтэй оруулсан 23 эрхийн улсын бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 1500 тоот дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн холбогдох засвар өөрчлөлтийг оруулан, илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.

Бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор байгууллагаас болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан “Цахим гадаад паспорт олголтын нээлтийн үйл ажиллагаа”, Хуульчдын “Про боно өдөр-2023”, Хаан банктай хамтарсан “Тоон гарын үсэг

олголтыг идэвхижүүлэх аян” болон нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд идэвхитэй оролцлоо.


Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын улсын бүртгэгчид нь өөрт хувиарлагдсан зэргэлдээ 6 сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. ADB төсөл хэрэгжиж эхлэснээр цаашид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгчийн тоог нэмэгдүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ онд шинээр Дарьганга сумын улсын бүртгэгч эрхзүйч мэргэжил эзэмшсэн ба Уулбаян, Түмэнцогт сумдын улсын бүртгэгч нар Эрхзүйч мэргэжлээр элсэн суралцаж байгаа юм. Мөн нийт улсын бүртгэгч нар хүний нөөц, сургалтын системд байршуулсан Эд хөрөнгийн эрхийн болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн холбогдох хичээлүүдийг бүрэн судалж, холбогдох шалгалтуудаа бүрэн өгсөн байна.

НАЙМ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хэлтсийн даргын 2023 оны 05 дугаар сарын 22- ны өдрийн Б/13 тоот тушаалаар байгуулагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хувийн хэргийг тоолох комиссын бүрэлдэхүүнтэйгээр архивын 1370 хувийн хэрэгт тооллого хийж, цахим сантай тулган, гарсан алдаа зөрчлийг тухай бүр нь залруулан ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 417 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд тайлант хугацаанд 100 бүртгэгдснийг графикаар харуулбал:



Шилжин ирсэн хуулийн этгээдийн 9, Шилжин явсан хуулийн этгээдийн 2 бүртгэлийг тус тус хөтөлж хувийн хэргийг зохих журмын дагуу архивт шилжүүлсэн байна.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт давхардсан тоогоор нийт 166- г бүртгэсэн байна. Үүнийг бүртгэлийн төрлөөр авч үзвэл:



Төрийн бус байгуулагуудын 2022 оны үйл ажиллагааны тайлангаа 02 сарын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх тухай хуульд заасны дагуу сумдын улсын бүртгэгч нартай хамтран ажиллаж 70 хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч архивлан хүлээлгэн өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах тухай” А/1345 дугаар тушаал, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 4/7456 тоот чиглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараахь арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS системээр ирүүлсэн Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн жагсаалтаас тус аймгийн хаягт бүртгэлтэй нийт 95 хуулийн этгээдийн архивын цаасан хувийн хэргийг архивийн сангаас татуулан авч, нэг бүрчлэн жагсаалттай тулгаж, хэлбэр тус бүрээр нь ангилан тусгаарлаж, архивын тавиурын нэг эгнээнд байрлууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус нэгж дээр хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан, цахимжуулж, хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивт шилжүүлэн ажилласан байна. Үүнд: Шинээр байгуулагдсан Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл -12 , Салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд орсон өөрчлөлт -10 бүртгэгдсэн.



Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/07 тоот тушаалаар томилогдсон комиссын гишүүдийг байлцуулан, Устгах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаснаар нэр бүхий хуулийн этгээдүүдийн хүчингүй болгосон 32 ширхэг тэмдгийг устгаж, акт үйлдэв.

ЕС. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус тасаг нь УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсаны дагуу ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, архивчийн бүрэлдэхүүнтэйгээр иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн бодитой ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг ханган иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэдэд шударга, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, түүний чанарыг олон улсын жишигт хүргэх зорилготой ажиллаж байна.

Иргэний бүртгэлийн тасаг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 20686 бүртгэл, 4768 лавлагааг иргэнд, 3655 лавлагааг албан хэрэгцээнд, 718 лавлагааг хууль хяналтын байгууллагад нийт 9141 лавлагааг тус тус олгон ажиллалаа.

Нийт сумдын улсын бүртгэгч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан хуулийн хугацаанд хэлтсийн даргаар батлуулж, хагас жилээр болон, жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт болон тайланг нэгтгэн аваад байна.





ХААН банктай хамтарсан “Төр хувийн хэвшлийн түншлэл”-ийн хүрээнд 2023 оны 3 дугаар сарын 31-ны өдөр Тоон гарын үсгийн ололтыг эрчимжүүлэх аяны удирдамж батлагдаж уг аяны хүрээнд төлөвлөгөө хуваарь гаргаж, улсын бүртгэгч нар хуваарийн дагуу ХААН банкаар үйлчилгээ авч байгаа иргэдэд тоон гарын үсгийн ач холбогдол түүний олголтын талаар тайлбарлаж иргэний үнэмлэхний чипэнд болон gsign аппликэшнаар нийт 2704 иргэнд тоон гарын үсэг олгож, нийт дүнгээр 11491 иргэн тоон гарын үсэг авч аймгийн 16 ба түүнээс дээш насны нийт иргэдийн 26,96 хувь нь хамрагдаад байна.



2023 оны 3 дугаар сараас эхлэн иргэдэд олгож эхэлсэн цахим гадаад паспортын



олголт жилийнэцсийн байдлаар нийт 3685 иргэнд цахим гадаад паспортыг олгосон байна.



Тус тасаг нь үйл ажиллагаандаа Монгол улсын “Үндсэн хууль”, “Иргэний хууль”, “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Иргэний улсын бүртгэлийн тухай хууль”, “Гэр бүлийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Тэмдэгтийн хураамжийн тухай хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Хувь хүний нууцын тухай хууль”, “Архивын тухай хууль”, “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль”-ууд болон эдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудыг өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Энэ онд тус аймгийн Уулбаян сумын 2,4-р багууд дээр сумын ИТХ-ын нөхөн сонгууль зарлагдсантай холбогдуулан сонгуулийн election.gazar.mn системд хэсгийн мэдээлэл, нутаг, дэвсгэр, санал авах байрны мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэсэн. 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр сонгогчийн нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэж, сумын сонгуулийн хороо, итгэмжлэгдсэн ажилтанд

хүргэж, хүлээлцэх акт үйлдсэн. Мөн сонгуулийн тоног төхөөрөмжийг Иргэний бүртгэлийн газраас тогтоосон хугацаанд очиж аван, сумын итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгсөн бөгөөд уг сонгуулиар Уулбаян сумын 2-р багийн 547, 4-р багийн 177 иргэн тус тус сонгуулийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн.



Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нарт мэдээллийн сангийн засвар өөрчлөлтийн эрх олгосон хугацаанд 0-16 насны хүүхдийн төрсний бүртгэлд нийт 85 иргэний мэдээлэлд нэмэлт өөрчлөлтийн бүртгэл оруулсан. Иргэний бүртгэлийн газраас нийт 19 удаагийн иргэний улсын бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэл ирсэнийг хэлтсийн болон сумдын бүртгэгч нарт дотоод группээр дамжуулан түргэн шуурхай хүргэж, ажилдаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад j.narantuya@burtgel.gov.mn хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Т.Байгальмаад t.baigalmaa@burtgel.gov.mn хаягаар мөн Иргэний бүртгэлийн тасгийн сар бүрийн тайланг p.enkhnar@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр тоон мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэвэл:


- ✚ Төрсний бүртгэлд 1124 хүүхэд бүртгүүлснээс 585 нь эрэгтэй, 539 нь эмэгтэй,
- ✚ Гэрлэлтийн бүртгэл 141
- ✚ Гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 37 бүртгэгдсэнээс захирааны журмаар 5, шүүхийн журмаар 32
- ✚ Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 14
- ✚ Эцэг тогтоолтын бүртгэл 61
- ✚ Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 38

- + Нас барсны бүртгэл 271
- + 16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан бүртгэл 825
- + Иргэний үнэмлэхний дахин олголт 282
- + Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1288
- + Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 3685
- + БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 0
- + БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 0
- + Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 493
- + Регистрийн дугаарын өөчлөлтийн бүртгэл 1
- + Аймаг доторх шилжилт хөдөлгөөн 2163
- + Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг нэгтгэвэл :
- + Албан хэрэгцээнд 3655
- + Хууль хяналтын байгууллагад 718
- + Иргэнд 4768
- + Төрийн болон төрийн бусад байгууллагад өгсөн лавлагаа 0

Хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Улиастай хотоор хилэлдэг Эрдэнэцагаан суманд 2 хоног ажиллах хугацаанд улсын бүртгэгч Ц.Алтанцэцэг тус суманд үндэсний энгийн гадаад паспорт болон цахим гадаад паспортын хэрэглээ түүний ач холбогдолын талаар сумын иргэдэд сурталчилж 200 гаруй иргэнээс гадаад паспортын захиалга авч ажилласан. Мөн 2023 оны 10 дугаар сарын 11-нээс 12-ны өдрүүдэд Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөрийн шинэ сэргэлтийн зургаан бодлогын нэг боомтын сэргэлтийн хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалттай танилцах хууль сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг болон “Бичигт-Зүүн Хатавч” боомтын хамтын ажиллагааны хүрээнд хоёр боомтын захиргааны хамтарсан намрын үзэсгэлэн арга хэмжээнд Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг “Бичигт-Зүүн Хатавч” боомтын захиргаан дээр 2 хоног ажиллаж тухайн боомтон дээр ажиллаж байгаа ажилтан албан хаагч, экспортын тээвэрлэлт хийж буй жолооч нарыг улсын хилээр саадгүй түргэн шуурхай нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 80 гаруй иргэний цахим гадаад паспортын захиалга авч ажилласан.



Мөн Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Наран, Сүхбаатар, Баяндэлгэр сумдуудад энгийн цахим гадаад паспортын захиалга авч ажилласан



2023 оны 01 дүгээр сарын 03-ны Хэлтсийн даргын “Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ХАСХОМ-ын тухай”, 2023 оны 02 дугаар сарын 10-ны, 03 дугаар сарын 23-ны “Бүртгэл болон ажлын байрны анхаарах асуудал” цахим сургалтаас хэлтсийн бүх албан хаагчид удирдлага, арга зүйн зөвлөгөө авсан.

2023 оны 01 дүгээр сарын 19-нд “Иргэний үнэмлэхийн зураг засварын программ ашиглах заавар, анхаарах асуудал”, 2023 оны 02 дугаар сарын 17-ны “Цахим гадаад паспортын программын танилцуулга”, 2023 оны 02 дугаар сарын 25-ны “Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх”, 2023 оны 03 дугаар сарын 20-нд “Цахим гадаад паспортын талаар чиглэл өгөх”, 2023 оны 03 дугаар сарын 29-нд “Засвар өөрчлөлтийн бүртгэлийн талаар чиглэл өгөх”, 2023 оны 04 дүгээр сарын 18-нд “ НАГ-аас болон тамгын газрын хамтарсан чиглэл өгөх”, 2023 оны 04 дүгээр сарын 24-нд “ХШГ болон ИУБГ-ын хамтарсан албан шаардлагын талаар чиглэл хүргүүлэх”, 2023 оны 04 дүгээр сарын 28-нд “Д.Дэлгэрсайхан-Аймаг, дүүргийн УБХ-ийн дарга, иргэний ахлах, Нэгдсэн төвүүдийн ахлахуудад чиглэл хүргүүлэх” талаар ахлах бүртгэгч нарт чиглэл өгөх тухай УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтад тус тус хамрагдсан болно.

2023 оны 03 дугаар сарын 28-нд “Амьдрах урлаг”, 2023 оны 04 дүгээр сарын 20-нд “Эрүүл мэндийн даатгал, ашиглалтын тухай” болон бусад сургалтад тус тус цахимаар оролцсон.

2023 оны 04 дүгээр сарын 03-нд сумдын улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэлтэй холбоотой асуудал” сэдвээр арга зүйн онлайн сургалтыг зохион байгуулсан.

2023 оны 01 дүгээр сарын 09-нд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас “Шинэ хуулийн төсөл”, 2023 оны 03 дугаар сарын 03-нд Монгол банкнаас “Цахим залилан”, 2023 оны 04 дүгээр сарын 12-нд ХААН банкнаас “Аяны хүрээнд хамтран ажиллах” сэдэвт сургалтуудад бүх албан хаагчид оролцсон.

АРАВ. САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭЭР

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны тайлангийн тодруулга тайлбар

Урсгал санхүүжилт:

Тус хэлтэс нь 2023 онд Улсын төсвөөс 1-11-р сарын байдлаар 617,9 сая төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар 4,5 сая төгрөг нийт 622,4 сая төгрөгийн санхүүжилтээр бүртгэлийн үйл ажиллагааг явуулсан байна. Нэмэлт санхүүжилтээр орж ирсэн 4,5 сая төгрөг нь Уулбаян сумын нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад: Үүнд: Итгэмжлэгдсэн ажилтны томилолт, цалин, нэрийн жагсаалт хэвлэх, хэсгийн хороонд хүргэх зардал, тоног төхөөрөмж хотоос авах, хүргэх зардал, гэх мэт зардлууд гарсан. Үлдэгдэл үлдээгүй болно. 617,9 сая

төгрөгийн санхүүжилтээр: Албан хаагчдын цалинд 489,9 сая, ажил олгогчоос төлөх НДШ-д 79,6 сая, тогтмол зардалд 14,7 сая, хангамж, бараа материалын зардалд 10,7 сая, эд хогшил худалдан авах зардалд 3,4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардалд 8,6 сая бараа үйлчилгээний бусад зардалд 0,3 сая / 80802/ буюу ажил олгогчоос олгох тэтгэмжид 1,4 сая төгрөг нийт 608,2 сая төгрөгийг зарцуулж 9,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үйлчилгээний орлого:

2023 онд тус хэлтэс нь улсын төсөвт 110,0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласанаас 1-11-р сарын байдлаар улсын төсөвт 115,0 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан. Хэлтсийн улсын бүртгэгч нарын орлогын тайланг сар сараар нь авч мөн үнэт цаасны тайланг сар бүр авч нэгтгээд УБЕГ-ын СААХ-т хүргүүлэн ажиллаж байна.

Авлага:

2022 оны жилийн эцсээр 19,9 сая төгрөгийн авлагатай гарсан. 2023 оны 1-р улиралд багтаан авлагыг хаасан болно.

Өглөг:

Байгууллагад төлөх өглөг 2023 оны 11-р сарын байдлаар 9,3 сая төгрөгийн НДШ-ийн өглөгтэй байна. Үүнийг жилийн эцсээр барагдуулж өглөггүй ажиллахыг төлөвлөж байгаа.

Барилга:

20,8 сая төгрөгийн эхний үлдэгдэл дээр Аймгийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдаж конторын барилга нь манай хэлтэст шилжин ирсэн 91,5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн. Хуримтлагдсан элэгдэл 30,1 сая төгрөгийн элэгдэл бодогдсон үлдэгдэл 82,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Машин тоног төхөөрөмж:

184,7 сая төгрөгийн эхний үлдэгдэл дээр УБЕГ-аас шилжин ирсэн 41,4 сая , үнэ төлбөргүй, аймгийн мэргэжлийн хяналтын газраас бүтцийн өөрчлөлтөөр шилжин ирсэн 57,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 99,1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Нийт хуримтлагдсан элэгдэл нь 155,3 сая төгрөг машин тоног төхөөрөмжийн дүн 127,6 сая төгрөг байна.

Тавилга:

14,2 сая төгрөгийн эхний үлдэгдэл дээр нийт 54,8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж УБЕГгазарт шилжүүлсэн 19,9 төгрөг хуримтлагдсан элэгдлээр 29,1 сая төгрөг үлдэгдэл хөрөнгө нь 19,9 сая төгрөг байна. Хөрөнгийн хөдөлгөөн хийгдээгүй болно.

Газар:

11,6 сая төгрөгийн эзэмшлийн газар дээр 103,4 сая төгрөгийн газар нэмэгдсэн нийт 114,3 сая төгрөгийн газартай.

Тус хэлтсийн 2023 онд 1-р гарын үсгийг Дарга Н.Бадрахцог 2-р гарын үсгийг Нягтлан бодогч С.Доржпагма миний бие Санхүүгийн тайлант онд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “НББ”-ийн тухай, “Төсвийн тухай” холбогдох хуулийн заалтын дагуу үнэн зөв бүрэн тусгасан болно.

АРВАН НЭГ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР


Сүхбаатар аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагчид, сумдын бүртгэгч нарын компьютер, принтер, каноны хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдалыг ханган тухай бүрт нь засаж сэлбэн, шинээр сольж ажиллаж байна. Улиралд 1 удаа хэлтсийн албан хаагчдын суурин болон зөөврийн компьютеруудын тоос тоосонцорыг цэвэрлэн ажиллаж байна. 2023 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 28 удаа засвар үйлчилгээг хийсэн. УБЕГ-аас өгсөн суурин компьютер 2 ширхэгийг олгосон. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг. БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сумын улсын бүртгэгч нарт компьютер 13 ширхэг, 3 үйлдэлт принтер 13 ширхэг, хурууны хээ уншигч 13 ширхэг, зургийн аппарат 13 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцөлийн бүрдүүлэн ажиллаж байна.



Хэлтэсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион

байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сарын бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь www.sukhbaatar.burtgel.gov.mn www.facebook.com/suburtgel гэсэн цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.




Тус хэлтэс нь 2023.05.01 өдрөөс эхлэн хуучин Мэргэжлийн хяналтын газрын байранд шилжин нүүн орсонтой холбогдуулан хэлтсийн дотоод сүлжээг Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК, интэрнэтийн сүлжээг UNIVISION LLC хамран шилэн кабель сүлжээний раакуудыг шинээр зоон байршуулсан. Хэлтсийн ажилтан албан хаагчидын дотоод сүлжээ болон интернэтийн сүлжээг шинээр татан ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утасгүй эмх цэгцтэй шинээр ил гарсан утсуудыг бүрэн далдалсан. Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байна.



Сүхбаатар аймаг эрчим хүчний эх үүсвэрийн хувьд төвийн бүсийн эрчим хүч Багануур дүүргээс болон Дорнод бүсийн эрчим хүч ТӨК Дорнод аймгаас харъяалалтай байдаг бөгөөд өдөр бүр 2-3 удаа тог тасарч 13 сумын шилэн кабел болон тоног төхөөрөмж байнга шатаж байдаг. 2023 онд 6 сумын рүүтер гэмтэж шатсанаас 3 сумын рүүтер, 3 сумын рүүтерийн тэжээлийн залгуур шатсан.

2019-2023 онд 13 сумын шилэн кабелийн медиа конвертерын тэжээлийн залгуур шатсаныг шинээр сольж хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Сүхбаатар аймгийн 13 сумын бүртгэлийн хэмжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.



Баруун-Урт сумын Улсын бүртгэгч 2023.03.16 нд Green town хотхоны "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-д шилжиж ажиллах болсон тул дотоод сүлжээг Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК LLC хамран



2023.1.23 нд Улсын бүртгэлийн өөртөө үйлчлэх киоск машин шинээр форматлан тохируулан суурьлуулж Улсын бүртгэлийн лавлагааг үнэ төлбөргүй, хялбар, хурдан шуурхай авахаас гадна ТООН ГАРЫН ҮСЭГ авах боломжтой болгосон. Одоогоор Баруун-Урт сумын "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-д хэвийн ажиллаж байна.



2023.06.18 нд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 2-р баг Жаргалант 15-11-2, 4-р баг Жавхлант 15-11-4 хэсгүүдэд Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгууль тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган, итгэмжлэгдсэн ажилтанд нэрсийн жагсаалт хэвлэх, ирц өүртгэлийн программ дээр ажиллах заавар зөвлөмж өгч ажилласан

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ:

Б. ОДОНЗУЛ

ХЯНАСАН:

СҮХБААТАР АЙМГИЙН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БАДРАХЦОГ